

Судрын адислал

Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Д.Тодд Кристоферсон

Бүх судрын үндсэн зорилго бол Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христэд итгэх итгэлээр бидний бие сэтгэлийг дүүргэх явдал мөн.

1536 оны 10 дугаар сарын 6-нд нэгэн зүдэрсэн эрийг Бельгийн Брюсселийн ойролцоох Вилворде Цайз доторх гяндангаас гадаа гарган авчирчээ. Тэрээр бараг жил хагас чийгтэй, харанхуй гяндангийн өрөөнд үйлээ эдэлсэн ажээ. Сайхь хоригдлыг эдүгээ цайзын хэрмийн гадна талд шонд хүлсэн байлаа. Тэрээр сүүлчийнхээ залбирлыг чангаар “Эзэн минь ээ, Англи улсын хааны нүдийг нээгээч” гэж хэлээд дүүжлүүлсэн гэнэ. Тэр даруй түүний цогцсыг шонд хүлээтэй чигээр нь шатаажээ. Энэ хүн хэн байсан юм бол? Улс төрийн болон шашны эрх баригчид түүнийг цаазаар авах ямар хэрэг хийсэн юм бол? Түүний нэрийг Виллям Тиндейл гэдэг байсан бөгөөд Библийг англи хэлээр орчуулж, хэвлэсэн нь түүний үйлдсэн гэмт хэрэг байлаа.

Колумбыг далай гатлан аялж шинэ дэлхийг нээсэн үед Тиндейл Англид төрсөн ажээ. Тэрээр Оксфорд, Кембрижийн их сургууль төгсөөд Католик шашны лам нарын нэг болжээ. Тэрээр грек, еврей, латин гэх мэт найман хэлийг чөлөөтэй мэддэг байжээ. Бас Библийн үнэнч сурагч байсан бөгөөд лам нар болон шашны бус хүмүүс бүгд судруудыг огт мэддэггүй байдал ихэд газар авсныг ажиглан улмаар санаа нь ихэд зовдог байжээ. Судрыг жирийн хүний гарт өгөхийн эсрэг бодолтой нэгэн хувраг хүнтэй ихэд маргалдах үедээ Тиндейл, “Бурхан миний амийг хамгаалах юм бол, би анжисаа түрэгч тариачин хүүг Судрын тухайд танаас дутуугүй мэдлэгтэй болгоно!” гэж тангарагласан гэдэг. Бүх хүмүүс Бурханы үгийг уншиж хэрэгжүүлэх боломжтой болгохын тулд тэрээр Библийг англи хэл дээр орчуулах зөвшөөрлийг сүмийн эрх мэдэлтнүүдээс хүссэн ажээ. Санваартуудаас өөр хүмүүст судруудыг боломжтой болгосноор сүмийн эрх мэдэлд саад болно, энэ нь “өөрсдийн сувдыг гахайн өмнө хаясантай” агаар нэг хэмээн үзсэний улмаас түүний хүсэлтийг зөвшөөрөөгүй гэдэг. Гэсэн ч Тиндейл орчуулгын хэцүү ажлыг өөр дээрээ

авчээ. Тэрбээр 1524 онд Германд өөр нэртэй болон очоод, баривчлагдахаас байнга айж, нуугдмал амьдарч байв. Үнэнч найз нөхдийн хүчээр Тиндейл Шинэ Гэрээг хэвлүүлж хожим нь бас Хуучин Гэрээг англи хэлээр хэвлүүлжээ. Библийг Англи уруу нууцаар хил нэвтрүүлсэн гэдэг. Тэнд Библийг маш олон хүн авах хүсэлтэй байсан төдийгүй олж авсан хэн бүхэн Библийг туйлын өндрөөр үнэлж байжээ. Библийг нууцаар өргөн хүрээнд тараасан байна. Эрх баригчид олсон бүх Библийг шатаасан ажээ. Гэсэн ч Тиндейлийг нас барсны дараа гурван жилийн дотор Бурхан VIII Хаан Хенригийн мэлмийг нээж, “Агуу Библи” хэвлэгдэн, судрууд нь англи хэлээр олон нийтэд хүртээмжтэй болсон юм. Тиндейлийн орчуулга Библийг хожим нь англи хэлээр орчуулсан орчуулгуудын үндэс суурь болсон ажээ. Эдгээр орчуулгуудаас хамгийн чухал нь Хаан Жеймсийн орчуулга юм.¹

Виллям Тиндейл өөр олон оронд Бурханы үгийг харанхуйгаас авчрахын төлөө, бүр амь насаа алдах хүртлээ золиослол хийсэн хүмүүсийн анхных нь ч мөн сүүлчийнх нь ч биш юм. Бид тэдэнд үлэмж их талархах ёстой. Нөр хичээнгүй хөдөлмөр, золиослол гарган түүхийн олон жилийн туршид судрыг цэдэглэн хадгалсан хүмүүст бид бүр ч их талархах ёстой. Эдгээр хүмүүст Мосе, Исаиа, Абрахам, Иохан, Паул, Нифай, Мормон, Иосеф Смит болон өөр олон хүн ордог. Судруудын ач холбогдлын талаар бидний мөн мэдэх хэрэгтэй ямар зүйлийг тэд мэдэж байсан юм бол? Англид 16-р зуунд Библийг өөрсөддөө авахын тулд маш их үнэ төлөөс төлж, аюул заналыг сөрөн тэмцсэн хүмүүс бидний одоо ойлгох хэрэгтэй ямар зүйлсийг ойлгосон юм бол?

Бошиглогч Алма нас барахынхаа өмнө ард түмнийхээ ариун цэдгийг хүү Хиламанд итгэл хүлээлгэн өгсөн билээ. Судрууд “энэ хүмүүсийн ой ухааныг тэлж, тийм ээ, мөн тэдний олонд замуудынх нь алдааг ойлгуулж; мөн тэднийг бодгалийнх нь авралд хүргэхээр Бурханых нь мэдлэгт авчирсаар ирсэн юм” (Алма 37:8) гэж тэрээр Хиламанд сануулжээ. Бурхан “ирээдүйн үеийнхэнд өөрийнхөө хүчийг үзүүлж болохын тулд” (Алма 37:14) тэрээр энэхүү цэдгүүдийг хадгалж хамгаалахыг Хиламанд тушаасан юм.

Бурхан судруудаар дамжуулан хүүхдүүдээ авран өргөмжлөх “өөрийнхөө хүчийг үзүүлдэг” юм. Алмагийн хэлснээр, Бурхан Өөрийнхөө үгээр дамжуулан хүмүүсийн ой ухааныг тэлж, худал бурууг залруулж, биднийг нүглээ наманчлан, өөрсдийн Гэтэлгэгч, Есүс Христэд баясахад хүргэдэг.

Судрууд бидний оюун ухааныг тэлдэг

Их Эзэнээ болон Түүнтэй мөн Эцэгтэйгээ ямар харилцаа холбоотойгоо үргэлж санахад бидэнд тусалснаар судрууд бидний оюун ухааныг тэлдэг юм. Судрууд мөнх бус байдлын өмнөх амьдралдаа бидний мэдэж байсан бүхнийг сануулж, бидний үзэж хараагүй өөр эрин зуун, хүмүүс болон үйл явдлуудын тухай заадгаараа бидний оюун ухааныг тэлдэг юм. Бидний хэн нь ч Улаан Тэнгис хоёр тал уруугаа хуваагдахад, Мосегийн хамт усан ханан дундуур нөгөө тал уруу нь гарч үзээгүй билээ. Уулан дээрх Есүсийн номлолыг сонсохоор, мөн үхлээс амилуулсан Лазарыг харахаар, Аврагчаа Гетсеманид болон загалмай дээр хэрхэн зовсныг харахаар тэр үед байгаагүй юм. Мөн бид хоосон агуйд хоёр тэнгэр элч Мариад Есүсийг амилсан гэж гэрчлэхэд тэнд байгаагүй юм. Та нар болон би Өгөөмөр нутагт цугласан олны дунд байж, амилсан Аврагчийн хүссэнээр хадаасны ормын сорвийг тэмтэрч, Түүний хөлийг нулимсаараа булхаагүй билээ. Бид Ариун ойн цоорхойд Иосеф Смитийн хажууд өвдөглөн сууж, Эцэг Хүү хоёрыг гайхширан хараагүй билээ. Гэсэн ч бидний мэдэхгүй зүйлсийг бидэнд зааж, оюун ухааныг маань тэлэх судрууд бидэнд байдаг учраас бид энэ бүхний тухай болон үүнээс ч илүү их зүйлсийг мэддэг билээ. Ингээд эдгээр зүйлс нь оюун ухаан болон зүрх сэтгэлд нэвтрэх үед Бурхан болон Түүний Хайрт Хүүд итгэх бидний итгэл соёолж эхэлдэг.

Судрууд нь мөн эртний үеийнхэн болон бид юу сурсныг мартахгүй байхад маань тусалснаар бидний ой ухааныг тэлдэг билээ. Бурханы цэдэглэгдсэн үгс өөрсдөд нь байхгүй эсвэл үүнийг үл ойшоодог тэдгээр хүмүүс аажмаар Түүнд итгэхээ больж, өөрсдийн оршихуйн зорилгыг мартдаг. Лихайн хүмүүс Иерусалимыг орхин явахдаа гуулин ялтсуудыг авч явсан нь хэчнээн чухал байсныг та нар санах болно. Эдгээр судрууд нь тэдэнд Бурханы тухай, хожим нь ирэх Христийн Гэтэлгэлийн тухай мэдэхэд зайлшгүй хэрэгтэй байсан юм. Лихайн дараахан Иерусалимаас гарч ирсэн өөр нэг бүлэг хүмүүст судар байгаагүй бөгөөд ойролцоогоор 300 эсвэл 400 жилийн дараа Лихайн удмынхан тэдэнтэй тааралдахад “тэдний хэл гуйвуулагджээ, мөн тэд өөрсдийг нь Бүтээгч байдгийг үгүйсгэсэн бөлгөө”(Омнаи 1:15, 17) хэмээн цэдэглэгдсэн байдаг.

Тиндейлийн үед хүмүүс Библийг олох боломжгүй, ялангуяа өөрсдийнх нь ойлгох хэл дээр байгаагүйн улмаас судрыг үл ойлгох нь өргөн дэлгэр тархсан байжээ. Харин өнөө үед Библи болон бусад судруудыг олж авахад үлэмж хялбар болсон ч судрыг үл ойлгох хүмүүсийн тоо нэмэгдсээр байна. Учир нь хүмүүс ном уншихаа

больжээ. Үүний улмаас тэд өвөө эмээгийнхээ мэддэг байсан зүйлсийг мартаж болжээ.

Судрууд бол үнэнийг худлаас ялгах жишиг мөн.

Бурхан худал хуурмаг бодол, буруу зан заншил, нүгэл болон үүний аймшигт үр дагаварыг залруулахдаа судрыг хэрэглэдэг. Тэрээр биднийг зовлон зүдгүүр, уй гашуугаас хамгаалахын зэрэгцээ бидэнд тэнгэрлэг хүч чадлаа ойлгоход тусалдаг нигүүлсэнгүй Эцэг юм. Жишээлбэл, судруудад мөн одоо үед дэлгэрч буй эртний нэгэн учир утгагүй философийг харуулдаг. Энэ бол ёс суртахууны ямар ч жишиг гэж байдаггүй, “хүн бүр өөрийн суу билгийн дагуу дэгжиж, мөн хүн бүр өөрийн хүчний дагуу ялан дийлдэг; мөн хүмүүний хийсэн юу боловч гэмт хэрэг бус,” “хүн үхэхэд түүний төгсгөл нь тэр” (Алма 30: 17-18) хэмээх Корихорын философи юм. Корихортой ярилцсан Алма хүү Кориантоныгоо тэнгэрлэг ёс суртахууны хуулийн бодит байдал болон утга агуулгынх нь талаар эргэлзээнд орхиогүй билээ.

Кориантон садар самууны нүгэлтэй байсан бөгөөд эцэг нь түүнд хандан хайраар, шулуун шударгаар: “Хүү минь, Их Эзэний мэлмийд эдгээр зүйл жигшүүрт хэрэг гэдгийг; тийм ээ, гэмгүй цусыг урсгах эсвээс Ариун Сүнсийг үгүйсгэхээс бусад бүх нүглүүдээс хамгийн жигшүүрт зүйл болохыг чи мэдэхгүй гэж үү?” (Алма 39:5) гэжээ.

Зуун жилийн өмнө амьдарч байсан хүмүүстэй огт адилгүйгээр өнөө үед садар самуун хэр зэрэг ноцтой болох тухай Алматай маргах хүмүүс олон бий. Зарим хүмүүс энэ нь орчин нөхцлөөс шалтгаалдаг гэж хэлнэ, эсвэл Бурханы хайрыг нигүүлсэнгүй, хүлцэнгүй гэж маргах болно. Хэрэв Бурхан байдаг л юм бол, Тэрээр бидэнд хайртай учраас бидний гэм нүгэл, алдаа дутагдлыг уулчилна шүү дээ. Ийм болохоор нүглээ наманчлах шаардлага байхгүй, буруугаа хүлээхэд л хангалттай гэж үздэг хүмүүс байдаг. Хүмүүс нийгмийн шударга ёсны төлөө зөвхөн тэмцэж харин хувийнх нь амьдрал, зан төлөвийг өөрчлөхийг шаарддаггүй тийм Есүсийг л тэд төсөөлж байна.² Гэвч хайрын Бурхан биднийг, “ёс бус явдалд хэзээ ч аз жаргал байгаагүй” (Алма 41:10, мөн Хиламан 13:38-г хар) гэдгийг эмгэнэлт тохиолдлоор олж мэдэг гээд зөнд нь орхидоггүй билээ. Түүний зарлигууд бодит үнэний дуу хоолой болж, өөрсдийгөө хохироох зовлонгоос хамгаалах хамгаалалт болж өгдөг юм. Судрууд бол зөвт байдал болон үнэний хэмжүүрийн жишиг бөгөөд Бурханы шударга ёсыг үгүйсгэх юмуу нүглийнхээ үр дагаварыг хүлээхгүйг эрэлхийлснээр биш, харин Бурханы Хүүгийн цагаатгагч ач ивээлээр дамжуулж нүглээ наманчлан,

өршөөгдснөөр жинхэнэ аз жаргал ирдэг гэдгийг тод харуулдаг (Алма 42-ыг үз). Шударга шулуун зан, үүрэг хариуцлагатай байдал, аминч бус байдал, найдвартай үнэнч байдал, энэрэнгүй байдал зэрэг соёлтой нийгмийг тогтооход зайлшгүй хэрэгтэй ёс суртахууны зарчмуудыг судрууд бидэнд заадаг билээ. Бид үнэний зарчмуудыг мөрдөн дагаснаас ирэх адислалууд болон хувь хүмүүс, соёл иргэншлүүд эдгээрийг үл ойшоон орхисноос ирдэг эмгэнэлт явдлын тод томруун олон жишээг судруудаас олж болно. Хаана ч бай судрын үнэнүүд алдагдаж, тэдгээр үнэнүүдийг үл ойшоосон үед нийгмийн ёс суртахууны суурь ганхаж, үүний уршгаар нийгэм ялзарч, доройтдог билээ. Эцэст нь нийгмийг тогтвортой болгогч ёс журмыг бататгах юу ч үгүй болж мэдэх юм.

Судрууд биднийг Гэтэлгэгч Христэд маань аваачдаг

Эцэст нь, судруудын гол зорилго нь Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христэд итгэх итгэлээр бидний оюун санааг дүүргэж өгдөг юм. Тэд байдаг гэдэгт итгэх итгэлээр, бидний үхэшгүй байдал болон мөнхийн амьдралд зориулсан Эцэгийн төлөвлөгөөнд итгэх итгэлээр, аз жаргалын төлөвлөгөөг боломжтой болгогч Есүс Христийн Амилалт болон Цагаатгалд итгэх итгэлээр, Есүс Христийн сайн мэдээг амьдралынхаа замнал болгох итгэлээр, “Цорын ганц үнэн Бурхан, болон Түүний илгээсэн Есүс Христийг” (Иохан 17:3) танин мэдэх тэрхүү итгэлээр судрууд бидний бодгалийг дүүргэх болно.

Алмагийн хэлснээр, Бурханы үг нь бидний зүрх сэтгэлд таригдсан үрийн адил бөгөөд энэ нь бидний дотор ургах үедээ итгэлийг бий болгодог юм. (Алма 32:27--43, Ром 10:13--17-г үз.) Итгэл нь эртний судрыг зөвхөн судалгааны зорилгоор судалснаар ирдэггүй. Энэ нь археологийн ухалт, нээлтээр ирдэггүй. Энэ нь шинжлэх ухааны туршилтуудаас ирдэггүй. Энэ нь гайхамшгийг нүдээр харснаас ч ирдэггүй. Эдгээр зүйлс нь итгэлийг баталж, эсвэл заримдаа сорьдог байж болно, гэвч итгэлийг бий болгодоггүй юм. Итгэл нь бид Бурханы үгийг сонсож уншсанаар Ариун Сүнс бидний оюун санаанд, Сүнснээс сүнсэнд, гэрчилснээр ирдэг юм.

Тэгээд бид үгийг баяртай хүлээн авсан үед итгэл маань өсдөг.

Судар дахь бусдын итгэлийн түүхүүд нь бидний итгэлийг хүчирхэгжүүлдэг. Нэгэн зуутын даргын итгэл нь зарцыг нь бүр харалгүйгээр эдгээх боломжийг Христэд олгож(Матай 8:5-13-ыг үз), мөн нэгэн канаан эмэгтэйн охиныг, ээж нь Эзнийхээ ширээнээс үүрмэгийг ч болов хүртэхээр даруухан байсан учраас эдгээсэн гэдгийг бид санаж байгаа (Матай 15:22-28; Марк 7:25-30-ийг үз). Зовж зүдэрсэн Иов, “Тэр

намайг алах ч гэсэн би Түүнд найдах болно” (Иов 13:15) хэмээн уйлж, нулимс урсган “Миний Золигч амьд гэдгийг болон эцэст нь Тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ...би махан биеэрээ Бурханыг харах болой”(Иов 19:25) гэснийг бид мэднэ. Бяцхан хөвгүүн- бошиглогч, олон насанд хүрсэн өдий төдий хүмүүсээр үзэн ядагдаж, хэрцгийгээр дорд үзэгдсэн ч --- “Би үзэгдэл харсан, би үүнийг мэдэх бөгөөд Бурхан ч үүнийг мэднэ гэдгийг мэднэ, би үүнийг үгүйсгэж чадахгүй, мөн үүнийг хийж зүрхлэх нь үгүй” (Иосеф Смит---Түүх 1:25) гэсэн эрс шийдэмгий үгсийг нь бид сонсож, зоригждог билээ.

Христийн сургаалыг заадаг учраас судрууд Эцэг, Хүү хоёрыг гэрчилдэг Ариун Сүнснийг (3 Нифай 11:32) авчирдаг юм. Иймээс судраас унших нь Ариун Сүнснийг хүлээн авах нэг арга зам юм. Мэдээж, судрууд нь анх Ариун Сүнсээр өгөгдсөн бөгөөд (2 Петр 1:21, Сургаал ба Гэрээ 20:26-27, 68:4) яг тэр Сүнс нь үүний үнэнийг та нарт болон надад баталж чаддаг юм. Судруудыг бодол зорилготойгоор судалж, тунгаан бодож, залбир. Судрууд нь илчлэлтүүдийг агуулдаг бөгөөд цаашид илчлэлтүүдийг авчрах болно.

Ариун Библийн зэрэгцээ Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд гэсэн ойролцоогоор 900 хуудас судруудтай байгаагаас ирдэг агуу адислалыг бодоод үз л дээ. Үүнээс гадна Ариун Сүнсээр нөлөөлөгдөн хэлсэн бошиглогчдын үгс телевизор, радио, интернет, хиймэл дагуул, компакт диск болон хэвлэлээр дамжин бидэнд байнга ирдгийг бодоод үз л дээ. Эдгээрийг Их Эзэн судар гэж нэрлэсэн юм (Сургаал ба Гэрээ 68:2-4-ийг үз) Хүмүүс ийм их ариун судраар адислагдсан төдийгүй эрэгтэй, эмэгтэй хүн бүр, мөн хүүхэд бүр эдгээр ариун судруудтай байж, тэдний олонх нь судруудыг төрөлх хэлээрээ унших боломжтой байгаа ийм цаг үе өмнө нь түүхэнд байгаагүй гэж би бодож байна. Ийм байдал Виллям Тиндейл болон эртний Гэгээнтнүүдэд ямар гайхамшигтай санагдах байсан бол! Их Эзэн энэхүү адислалаар дамжуулан бидний үед судруудыг үргэлж хэрэглэж, судлах нь урьдын ямар ч цаг үеэс илүү чухал юм гэж хэлж байна. Бидэнд юу хийх ёстойг заах Христийн үгнээс бид үргэлж зооглох болтугай. (2 Нифай 32:3-ыг үз) Би судруудыг судалж, тунгаан бодсон бөгөөд та бүхэнд Христийн амилалтын баярыг тохиолдуулан ариун судруудад илчлэгдсэн Эцэг Хүү хоёрын тухай Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

1. Вильям Тиндейлийн тухай мэдээллийн эх сурвалжууд, Давид Даниелийн *The Bible in English* (Иелийн их сургуулийн хэвлэл, 2003), 140--157; Ленет Хайдли Рийдийн, *How We Got the Bible* (Deseret Book, 1985), 67--74; S. Майкл Вилкоксын, *Fire in the Bones: William Tyndale, Martyr, Father of the English Bible*, Deseret Book, 2004;¹ Жон Фоксын (Хайролд Чайдваикаар дахин бичигдэж, шинэчлэгдсэн), *The New Foxe's Book of Martyrs* (Bridge-Logos Publishers, 1997), 121--133;² William Tyndal, in *Wikipedia*, http://en.wikipedia.org/wiki/William_Tyndale, accessed February 28, 2010.

2. Майкл Дэ Грүүтийн "Questioning the alternative Jesus," *Deseret News*, Mormon Times, Nov. 29, 2009 номон дахь Ричард Нийцэл Холзафелтэй хийсэн ярилцлагыг үз.

¹ These items have not been translated in your language. Leave the underlined information in English.

² If this item has not been translated in your language, leave the underlined information in English.